



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД ЧИМЭДИЙН
САЙХАНБИЛЭГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2016.04.15 № 7/2719

танай _____-ны № _____-т

Хуулийн хэрэгжилтийг хангаж
арга хэмжээ авч ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4-т “Өргөдлийн байнгын хороо нь өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу тайлбар авах ээлжит уулзалтыг 2016 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Уг уулзалтаар айл өрхийн цахилгааны төлбөрийг аж, ахуйн нэгжийн тарифаар авч байгаа, шинээр худалдан авч байгаа орон сууцны талбай гэрээнд заасан хэмжээнд хүрэхгүй иргэдийг хохироож байгаа асуудлаар холбогдох албан тушаалтнаас тайлбар, мэдээллийг авч, иргэдийг хохироож байгаа шалтгаан нөхцөлийг тодрууллаа.

Төрийн захиргааны байгууллагуудын зүгээс Барилгын тухай, Орон сууцны тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Эрчим хүчний тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, норм норматив, стандартын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, иргэдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх ажил дутагдалтай, зөрчил гаргаж иргэдийг хохироож байгаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, хохирлыг барагдуулах асуудлыг шуурхай шийдвэрлэхгүй байгаагийн улмаас дээрх асуудлууд үүсч, иргэдийг хохироож байгаа тул холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд асуудлыг шуурхай шийдвэрлэж, иргэдийн гомдол, хохирлыг барагдуулж ажиллах үүрэг өгч ажиллан, 2016 оны 5 дугаар сард багтаан биелэлтийг Байнгын хороонд ирүүлнэ үү.

Түүнчлэн дээрх асуудлуудыг мэргэжлийн хяналтын болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага тогтоож, дүгнэлт гаргадаг тул орон сууцыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд эдгээр байгууллагуудын төлөөллийг оруулах шаардлагатай байна. Иймд Засгийн газрын 2012 оны 151 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 3 дугаар хавсралтад нэмэлт оруулах асуудлыг судлан үзнэ үү.

Хувийг: Эрчим хүчний сайд Д.Зоригт, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ц.Шаравдорж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Д.Мөнхтөр, Нийслэлийн Баянзүрх дүүрэг 13-р хороолол 6 дугаар хороо 31 дүгээр байранд байрлах “Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоо” ТББ-ын Ерөнхийлөгч

0000091350


А.Ариунболд /91180789 /, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны 11 дүгээр байранд оршин суугч Д.Мягмарсүрэн /91020606/, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны Сүмбэр орд 603 дугаар байрны оршин суугч Т.Мэндсайхан /99992240/ нарт.

Байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдийг хавсаргав.

Хавсралт 41 хуудастай.

Хүндэтгэсэн,

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.БАТЗАНДАН